



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/669.

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны XXV/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Шуурхай мэдээллийн төвийн тоног төхөөрөмж (Булган сум) нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга:

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын дарга)

Гишүүд:

А.Гэрэл (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

Ё.Хулан (Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл:

О.Буянбат (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Будцэцэг (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010959